



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

Э-сонин

12-Р САР

65-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2018.12.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	20
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	5,417,410,085.85
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	4,536,811,565.85
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	880,598,520
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	38,298,936
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	38,290,626
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	8,310
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	2,891


Зах зээлийн үнэлгээ



TOP-20 индекс




MSE A индекс



/Нэгж/

MSE B индекс



/Нэгж/

Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	216
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	11
Хувийн өмчийн	187
I ангилал	13
II ангилал	42
III ангилал	167

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн үнэт цаасны компанийн тоо	61
Үүнээс: Брокер, Дилер	52
Андеррайтер	24
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2018.12.31-ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Голомт Капитал ХХК	119,045,525	85,594,922,732.48	118,260,067	86,203,337,377.16	171,798,260,109.64
2	Ти Ди Би Капитал ХХК	3,406,604	31,946,968,983.64	2,298,929	30,238,451,784.08	62,185,420,767.72
3	Бумбат-Алтай ХХК	2,575,396	797,513,116.40	1,875,468	1,302,669,093.48	2,100,182,209.88
4	Ард секюритиз ХХК	1,674,622	1,157,242,374.59	1,048,187	720,939,341.45	1,878,181,716.04
5	БиДиСек ХК	4201337	841784859.5	4819098	1346865734	2,188,650,593.72
6	Ард капитал групп ХХК	7816403	886173633.8	7748568	992315426.5	1,878,489,060.30
7	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	13459527	846269604.2	14776937	902169142.8	1,748,438,747.00
8	Стандарт инвестмент ХХК	826,928	139,104,749.63	1,855,977	285,244,295.54	424,349,045.17
9	Гаули ХХК	209,781	57,882,038.97	444,103	151,821,426.81	209,703,465.78
10	Алекс Капитал УЦК	212,795	69,582,944.04	180,548	127,279,368.00	196,862,312.04
11	Новел инвестмент ХХК	461,137	62,717,018.53	671,029	122,869,601.18	185,586,619.71
12	Тулгат чандмань баян ХХК	28,549	72,395,152.00	28,595	71,200,028.21	143,595,180.21
13	Монсек ХХК	81,064	27,493,701.00	141,626	47,284,588.40	74,778,289.40
14	Лайфтайм инвестмент ХХК	7,318	46,142,519.00	0	0.00	46,142,519.00
15	Санар ХХК	3,042	3,614,990.00	73,250	41,998,255.00	45,613,245.00
16	Батс ХХК	72,226	24,604,940.00	60,027	19,925,549.00	44,530,489.00
17	Гүүдсек ХХК	0	0.00	117,821	43,969,468.28	43,969,468.28
18	Зэргэд ХХК	158,435	20,700,865.80	52,998	20,202,736.20	40,903,602.00
19	Хүннү Эмпайр ХХК	94,283	33,660,428.00	9,361	2,426,976.00	36,087,404.00
20	Гендекс ХХК	16,151	6,024,323.00	72,200	25,631,000.00	31,655,323.00

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.12.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	HBO	ХАЙ БИ ОЙЛ	21,596,107	1,058,608,378.99	53.00	42.00	4.00	8.16
2	APU	АПУ	773,758	449,595,452.77	600.00	560.00	-17.06	-2.90
3	LEND	ЛЭНДМН ББСБ	5,796,581	417,031,990.29	75.99	68.00	-3.41	-4.57
4	AIC	АРД ДААТГАЛ	435,236	323,941,985.97	800.00	706.00	71.32	10.14
5	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	38,512	187,004,162.00	5,040.00	4,550.00	-210.00	-4.28
6	GOV	ГОВЬ	5,319	175,055,620.00	34,300.00	31,800.00	-960.00	-2.83
7	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС	292,485	174,285,513.20	610.00	520.00	39.76	7.23
8	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	206,884	156,312,475.00	950.00	550.00	340.00	58.62
9	TTL	ТАВАН ТОЛГОЙ	15,522	108,359,230.00	7,800.00	6,200.00	-1,150.00	-15.03
10	JIV	ЖИНСТ-УВС	67,826	107,895,551.00	1,799.00	1,277.00	172.00	10.68
11	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	312,858	99,127,598.24	335.00	295.00	-18.00	-5.66
12	ITLS	АЙГҮҮЛС	801,157	88,884,661.58	121.00	105.00	-8.07	-6.83
13	RMC	РЕМИКОН	1,360,067	33,990,261.62	31.99	24.00	-6.10	-19.00
14	MNP	МОНГОЛ ШУУДАН	42,377	22,921,128.00	590.00	501.00	45.01	8.34
15	HGN	ХӨХ ГАН	270,895	19,387,894.00	90.00	70.00	-18.99	-20.20
16	MIB	МОНИНЖБАР	101,351	12,737,603.90	153.00	85.00	-90.00	-50.00
17	TCK	ТАЛХ ЧИХЭР	597	12,096,400.00	21,000.00	19,500.00	-1,280.00	-5.88
18	SUU	СҮҮ	47,238	10,790,133.96	239.00	223.00	-2.16	-0.94
19	MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	35,804	7,296,590.00	220.00	200.00	-50.00	-20.00
20	BDS	БИ ДИ СЕК	6,068	5,818,038.00	1,000.00	930.00	-61.23	-6.12



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.12.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2018-12-01	2018-12-31		
1	МИК ХОЛДИНГ	2,005,124	10,350.00	14,750.00	4,400.00	42.51
2	ОЛЛОО	2,566	55.00	74.70	19.70	35.82
3	ШИВЭЭ ОВОО	1,490	1,710.00	2,295.00	585.00	34.21
4	ОРХОН ХӨГЖИЛ	198	216.20	285.92	69.72	32.25
5	МОНГОЛ САВХИ	524	550.00	724.50	174.50	31.73
6	ТАХЬ КО	10	10,200.00	13,400.00	3,200.00	31.37
7	ЖИНСТ УВС	139,063	1,783.00	2,341.00	558.00	31.30
8	МОНГОЛ ШИЛТГЭЭН	551	300.00	388.33	88.33	29.44
9	МАТЕРИАЛИМПЕКС	216	7,435.00	9,490.00	2,055.00	27.64
10	МЕРЕКС	44,433	26.00	31.97	5.97	22.96
11	БӨХӨГ	560	2,700.00	3,300.00	600.00	22.22
12	Э- ТРАНС ЛОЖИСТИКС	17,227	100.00	120.00	20.00	20.00
13	МОНГОЛ ШУУДАН ХК	267,094	585.00	684.03	99.03	16.93
14	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	100	800.00	920.00	120.00	15.00
15	БҮТЭЭЛЧ ҮЙЛС	19	1,300.00	1,495.00	195.00	15.00
16	СИЛКНЭТ	4	615.90	708.20	92.30	14.99
17	БАЯНТЭЭГ	14	15,900.00	18,280.00	2,380.00	14.97
18	УБ БҮК	2,636	335.00	385.00	50.00	14.93
19	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС	14	1,750.00	2,000.00	250.00	14.29
20	УЛААНБААТАР ХИВС	18	13,500.00	15,400.00	1,900.00	14.07

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.12.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-12-01	2018-12-31		
1	НАКО ТҮЛШ	7,588,685	172.50	109.70	-62.80	-36.41
2	ОРХОН ДАЛАЙ	240	2,400.00	1,800.00	-600.00	-25.00
3	МОНГОЛ БАЗАЛТ	420,218	300.00	241.08	-58.92	-19.64
4	БАГАНУУР	8,598	1,679.00	1,374.00	-305.00	-18.17
5	ЭРДЭНЭТ АВТОЗАМ	986	515.00	425.00	-90.00	-17.48
6	МОНИТ БУЛИГААР	10	8,800.00	7,500.00	-1,300.00	-14.77
7	ХӨВСГӨЛ ХҮНС	127	1,367.00	1,175.00	-192.00	-14.05
8	ДӨРВӨН УУЛ	18	1,500.00	1,300.00	-200.00	-13.33
9	ТАВ	2	11,500.00	10,000.00	-1,500.00	-13.04
10	СИЛИКАТ	18,100	120.00	105.00	-15.00	-12.50
11	УВС ЧАЦАРГАНА	536	400.00	350.00	-50.00	-12.50
12	АР БАЯНХАНГАЙ	40	800.00	700.00	-100.00	-12.50
13	ИХ БАРИЛГА	22,514	3,499.00	3,099.00	-400.00	-11.43
14	ДАРХАН ХҮНС	229	4,799.00	4,300.00	-499.00	-10.40
15	СҮҮ	782,989	227.10	204.00	-23.10	-10.17



МХБ-ИЙН ШИНЭЧЛЭН БАТЛАГДСАН "ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЖУРАМ" МӨРДӨГДӨЖ ЭХЭЛЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2018/15 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ыг 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороо батламжилснаар тус журмыг 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс мөрдөж эхэллээ.

Энэхүү шинэчлэн батлагдсан журам нь хөрөнгө оруулагчдаас захиалга хүлээн авах арга тус бүрийн онцлогийг харгалзан үнэ тогтоох, хуваарилалт хийх зарчмыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлсний зэрэгцээ бусад журмуудтай давхацсан зохицуулалтуудыг хасч, практик хэрэглээнд нийцүүлэх өөрчлөлтүүдийг оруулсан болно. Тухайлбал, тухайн нийтэд санал болгож буй үнэт цаасны 50 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчид хуваарилах эрхийг андеррайтерт олгох, тогтоосон үнийн аргын үед харилцагчийн захиалгыг нэг үнийн түвшинд хүлээн авч, хуваарилалтыг зөвхөн хувь тэнцүүлэх аргаар хийж, жижиг хөрөнгө оруулагчдыг дэмжих, дуудлага худалдааны үед захиалга бүртгэх хугацааг уртасгах зэрэг нэмэлт өөрчлөлтүүд үүнд багтсан юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ЦАХИМ ХУУДАС ШИНЭЧЛЭГДЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь өөрийн цахим хуудасны бүтэц, зохион байгуулалт, агуулгыг сайжруулан шинэчилж ашиглалтад орууллаа. Энэхүү шинэчлэгдсэн хувилбараар хөрөнгө оруулагчид бүртгэлтэй хувьцаат компаниудын мэдээллийг нүүр хуудсаар дамжуулан цаг алдалгүй, хялбар аргаар авах боломжтойгоос гадна "Таны мэдлэгт" булангаас хөрөнгийн зах зээлийн үндсэн ойлголт, арилжаанд хэрхэн оролцох тухай танилцуулга, хийсвэр арилжааны платформ болон хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох бусад мэдээлэл, материалуудтай танилцах боломжтой юм. Түүнчлэн, "Үнэт цаас бүртгүүлэх" цэснээс хөрөнгийн зах зээлд хувьцаа, бонд гаргах сонирхолтой компаниуд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох тухай мэдээ мэдээллийг нэг дороос авах боломж бүрдлээ.

"ТҮМЭН ШУВУУТ" ХХК НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн А/94 тоот тушаалаар "Түмэн шувуут" ХК-ийн нэг бүр нь 20 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, нийт 200,000,000 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн II ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцэж, 373 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 25 хувь буюу 50,000,000 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар буюу нэгж хувьцааг 200 төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн байна.

ҮЙЛ ЯВДАЛ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИЛДГҮҮДИЙГ ТОДРУУЛЛАА

Монголын хөрөнгийн зах зээлийн шилдгүүдийг тодруулдаг "GRAND BULL AWARDS 2018" ёслол хүндэтгэлийн арга хэмжээг Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооноос санаачлан "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК, "Монголын Үнэт Цаасны Бирж" ХХК, "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК, "Арилжааны Төлбөр Тооцоо" ХХК-иудтай хамтран 2018 оны 12-р сарын 13-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын өнгөрсөн дөрвөн жилд үзүүлсэн ололт, амжилтыг дүгнэн, номинаци тус бүрт нэр дэвшсэн шилдэг таван байгууллага/мэргэжилтэн/-с дараах шилдгийн шилдгүүдийг тодруулан "GRAND BULL AWARDS 2018" цомыг гардууллаа.

"GRAND BULL AWARDS 2018"-ийн номинаци тус бүрийн шилдгийн шилдгүүдэд:

"ШИЛДЭГ БРОКЕРИЙН КОМПАНИ"- "БИДИСЕК ҮЦК" ХК,
"ШИЛДЭГ ПРО" – "ЛэндМН ББСБ" ХК,
"ШИЛДЭГ ХУВЬЦААТ КОМПАНИ"- "ГОВЬ ХК",
"ШИЛДЭГ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИ"- "БИДИСЕК ҮЦК" ХК,
"ШИЛДЭГ МЭРГЭЖИЛТЭН"- Б.ӨЛЗИЙБАЯР/"Ард капитал ҮЦК"-ийн Гүйцэтгэх захирал/ тус тус шалгарлаа.

ХЭНТИЙ, ДОРНОД, СҮХБААТАР АЙМГУУДАД НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх ажлын хүрээнд зах зээлийн зохицуулагч болон мэргэжлийн байгууллагууд, "Эрдэнэс Тавантолгой" ХК-тай хамтран "Хөрөнгийн зах зээлийн нээлттэй өдөрлөг"-ийг Булган, Дархан-Уул, Орхон, Увс, Баян-Өлгий, Ховд аймгуудад амжилттай зохион байгуулсан билээ.

Орон нутгийн дараагийн өдөрлөгийг Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудад 2018 оны 12 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох, хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулахаас гадна "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй /ягаан цэнхэр тасалбар/ холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, арилжааны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх тул нутгийн иргэдийг өргөнөөр оролцохыг урьж байна.



ЗАРИМ КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Дархан мах экспо” ХК, “Эвлэл” ХК, “Ажлын хувцас” ХК-ууд нь татан буугдсан болох нь баримтаар тогтоогдсон, “АЗЗАН” ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй, “Бэрэн майнинг” ХК нь үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрч бүртгэснээс хойш зургаан сарын дотор тухайн үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргаагүй байх тул “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/139 тоот тушаалаар тус компаниудыг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн жагсаалтаас хаслаа.

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА НЬ ЗОГССОН ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23.11.4-т зааснаар үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш 1 жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл шалтгаан нь арилаагүй үнэт цаасыг Биржийн бүртгэлээс хасна гэж тусгасан байдаг.

Одоогийн байдлаар дээрх журмын дагуу 1 жилээс дээш хугацаанд арилжаа нь зогссон, арилжаагаа сэргээх талаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй нийт 29 компани байна. Иймд дээрх компаниуд хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн үнэт цаасны арилжаагаа сэргээх талаар Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргаж, үнэт цаасны арилжаагаа 2019 оны 02 сарын 28-ны өдрөөс өмнө сэргээж, энэ тухайгаа Монголын хөрөнгийн биржид мэдэгдэн МХБ-тэй байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг анхааруулж байна.

Дээрх хугацаанд үүргээ биелүүлээгүй, арилжаагаа сэргээх арга хэмжээ аваагүй компаниудыг журмын дагуу Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах болохыг мэдэгдэж байна.

"ГОВЬ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

СЗХ-ны 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар "Говь" ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөнтэй холбогдуулан Улсын байцаагчийн 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 57 тоот албан шаардлагын дагуу тус компанийн арилжааг 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар зогсоолоож. Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 58 тоот албан шаардлагаар "Говь" ХК-ийн хувьцааны арилжааг 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр нээлээ.

Үйл явдал

"БАЯН-АЛДАР" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

СЗХ-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй "Баян-Алдар" ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөнтэй холбогдуулан Улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 59 тоот албан шаардлагаар тус компанийн үнэт цаасны арилжааг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түр зогсоолоо.

"ЭРДЭНЭ РЕСУРС КОРПОРАЙШН" ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН АНХАН ШАТНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦООЛЛЫГ ТАНИЛЦУУЛЛАА

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" (TSX: ERD | MSE: ERDN) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн Хөндий алтны төслийн анхан шатны бөгөөд хөндлөнгийн эдийн засгийн тооцооллыг ("PEA") RPMGlobal Ltd (Хонг Конг) компаниар NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын дагуу боловсруулж олон нийтэд танилцуулсан байна.

Компани цаашид ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд үүний хажуугаар урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, 2019 оны эхээр уурхайн барилга байгууламж байгуулах, холбогдох бусад зөвшөөрөл авах ажлууд төлөвлөгдөж байна.

"БАЯН-АЛДАР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Баян-Алдар" ХК нь 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаараа "Монгорүматрикс Гинко" ХХК-тай нэгдэхээр шийдвэрлэсэн байна.

Үүнтэй холбогдуулан энэхүү асуудлын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1-д заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүсэнийг үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах хүсэлтийг хүлээн авч эхлэх огноо: **2018 оны 12-р сарын 24-ны өдөр**

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: **2019 оны 2-р сарын 4-ний өдөр**

Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ: **642 төгрөг**

Шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй бол "Баян-Алдар" ХК болон харилцдаг үнэт цаасны компанид хандана уу.

Шаардах эрх хэрэгжүүлэгч "Баян-Алдар" ХК : УБ, ЧД, 1-р хороо Аризона төв 12 тоот, Холбогдох утас: 70113980, 88008702



ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА

“Говь” ХК нь 2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 220 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, ногдол ашгийг 2018 оны 4 сарын 24-ний өдрөөс эхлэн компани дээрээ олгож байсан бол “ҮЦТХТ” ХХК-тай 2018 оны 12 сарын 21-ний өдөр байгуулсан гэрээний дагуу 2017 оны ногдол ашгийн үлдэгдэл болох 15,960 хувьцаа эзэмшигчдийн 800,789 ширхэг хувьцаанд ногдох 158,371,774 төгрөг /ХАОАТ суутгасан дүн/, мөн 2010-2016 онуудад зарласан ногдол ашгийн үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн дансанд 2018 оны 12 сарын 27-ны өдөр байршуулсан байна.

ХОЁР ГИШҮҮН ҮЦК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЭРХИЙГ ЦУЦАЛЛАА

Монгол Улсын Компанийн тухай хууль болон СЗХ, МХБ-ийн холбогдох дүрэм, журамд нийцүүлэн гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2018/17 тоот тогтоолоор “Би Би Эс Эс ҮЦК” ХХК, “Говийн ноён нуруу ҮЦК” ХХК-иудын биржийн гишүүнчлэлийн эрхийг цуцалж, гишүүнээс хаслаа.

Тус компаниудын харилцагчдыг СЗХ-ны 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 127 тоот тогтоолын дагуу “Бумбат Алтай ҮЦК” ХХК-д шилжүүлсэн тул гишүүнээс хасагдсан дээрх компаниудын харилцагчид нэмэлт төлбөр, зардал чирэгдэлгүйгээр үнэт цаасны дансаа үргэлжлүүлэн эзэмшиж, хөрөнгийн зах зээлийн харилцаанд саадгүй оролцох боломжтой юм.



ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Говь” ХК нь 2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 220 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, ногдол ашгийг 2018 оны 4 сарын 24-ний өдрөөс эхлэн компани дээрээ олгож байсан бол "ҮЦТХТ" ХХК-тай 2018 оны 12 сарын 21-ний өдөр байгуулсан гэрээний дагуу 2017 оны ногдол ашгийн үлдэгдэл болох 15,960 хувьцаа эзэмшигчдийн 800,789 ширхэг хувьцаанд ногдох 158,371,774 төгрөг /ХАОАТ суутгасан дүн/, мөн 2010-2016 онуудад зарласан ногдол ашгийн үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн дансанд 2018 оны 12 сарын 27-ны өдөр байршуулсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN